



УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААР ТӨСӨЛ ТӨСЛИЙН ДУГААР CWHB-01-B

ЭЦСИЙН ТАЙЛАН

“УС ХАЛААХ ЖИЖИГ ЗУУХ (УХЖЗ)-НЫ ЯНДАНГААС
ГАРАХ УТААНЫ ХИЙ ДЭХ БОХИРДУУЛАХ БОДИСЫН
ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭГ ТОГТООХ СТАНДАРТ
БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”

Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл, ТӨСЛИЙН УДИРДАХ
НЭГЖ- ийн захиалгаар



ШУТИС ЭХС-ийн Зуухны туршилт судалгааны төв боловсруулав.

Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бага тойруу-34,
ШУТИС-ийн хичээлийн 2-р байр
Утас: 323579, Факс: 976-11-323579, 99041705
Э-шуудан: Oidov_zh@Yahoo.com
Web хаяг: <http://www.must.edu.mn>

2016 оны 11-р сарын 28

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

| | |
|--|----|
| Товчилсон үгсийн тайлбар | 3 |
| I. Оршил | 4 |
| II. Төслийн гүйцэтгэлийн хураангуй | 5 |
| III. Төслийн явцын тайлан 2-оос хойших зөвлөхийн үйл ажиллагаа | 5 |
| Хавсралт1. | 6 |
| Хавсралт 2. | 36 |
| Хавсралт3. | 63 |
| Хавсралт4. | |

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

| | |
|---------|---|
| АХБ | - Азийн хөгжлийн банк |
| АББҮХ | - Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо |
| БОГУУХГ | - Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газар |
| БОГУУХХ | - Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс |
| БОНХАЖЯ | - Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам |
| ДБ | - Дэлхийн банк |
| ДБХГ | - Дэд бүтцийн хяналтын газар |
| ДТҮЭХ | - Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэн |
| ЗБ | - Зөвлөх баг |
| ЗТЛ | - Зуухны туршилтын лаборатори |
| ЗТСТ | - Зуухны туршилт, судалгааны төв |
| МСС | - Мянганы сорилын сан |
| МХЕГ | - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| НАЧА | - Нийслэлийн агаарын чанарын алба |
| НЗДТГ | - Нийслэлийн засаг даргын тамгын газар |
| НМХГ | - Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар |
| ОШХ | - Орчны шинжилгээний хэлтэс |
| СХЗГ | - Стандартчилал Хэмжил зүйн газар |
| ТУН | - Төслийн удирдах нэгж |
| УБ | - Улаанбаатар |
| УБЦАТ | - Улаанбаатар цэвэр агаар төсөл |
| УХЖЗ | - Ус халаах жижиг зуух |
| ЦУОШГ | - Цаг уур, орчны шинжилгээний газар |
| ШУТИС | - Шинжлэх ухаан технологийн их сургууль |
| ЭХС | - Эрчим хүчний сургууль |
| ЭХЯ | - Эрчим хүчний яам |

I. ОРШИЛ

Дэлхийн банк/Олон улсын хөгжлийн ассоциациас авсан хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа Улаанбаатар цэвэр агаар төсөл (УБЦАТ)-ийн хүрээнд “Ус халаах жижиг зуухны (УХЖЗ)- ны яндангаас гарах утааны хий дэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох стандарт боловсруулах зөвлөх үйлчилгээ” ажлыг гүйцэтгэхээр ШУТИС-ийн Зуухны туршилт, судалгааны төв болон Улаанбаатар цэвэр агаар төслийн ТУНэгж харилцан тохиролцож, 2016 оны 6-р сарын 22-нд гэрээ байгуулсан.

Энэхүү гэрээний дагуу ШУТИС-ийн Зуухны туршилт, судалгааны төвийн зөвлөх баг ажлын удирдамжийг баримтлан судалгааны ажлыг гүйцэтгэж эхлэлийн, явцын 1 ба 2-р тайланг захиалагчид хүлээлгэн өгсөн.

Энэ төслийн явцын 2-р тайлангаас хойш стандартын төсөлд гол оролцогч талууд болон холбогдох яам, мэргэжлийн байгууллагууд, үйлдвэрлэгчдийн албан ёсны санал, шүүмж, зөвлөмжүүдийг нэгтгэн тусгаж MNS 5041: 2016 “20 кВт хүртэл чадалтай ус халаах жижиг зуух. Техникийн ерөнхий шаардлага, турших арга ба яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын эцсийн хувилбарыг боловсруулж СХЗГазарт илгээн эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх үед гишүүдийн гаргасан саналаар ус халаах зуухнуудын стандарттай нэгтгэн MNS 5043: 2016 “4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” нэрээр үндэсний зөвлөлөөр оруулан хэлэлцүүлж батлуулсан.

Монгол улсын Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 2-р бүлгийн 4.1, 6.2-т заасны дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ус халаах жижиг зууханд холбогдох стандартуудыг шинэчилснээр ус халаах зуухнаас ялгарч байгаа агаар бохирдуулах бодисын хэмжээнд тавигдах шаардлага өндөрсөж, бохирдлыг бууруулахад чухал ач холбогдолтой суурь баримт бичиг болж байгаа юм.

Энэ тайланд төслийн хүрээнд хийсэн ажлын хураангуй, англи, монгол хэл дээр бэлтгэсэн стандарт, СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлын тэмдэглэл, стандартыг баталсан үндэсний зөвлөлийн тогтоолыг оруулсан.

II. Төслийн гүйцэтгэлийн хураангуй:

- 2.1 ШУТИС-ийн Зуухны туршилт, судалгааны төв ба Улаанбаатар цэвэр агаар төслийн ТУНэгжийн хооронд байгуулсан гэрээний дагуу зөвлөх баг ажлын удирдамжийг баримтлан гол оролцогч талуудыг тодорхойлж, ажлын график, хүний нөөцийн хуваарилалт, стандарт боловсруулах арга аргачлалыг багтаасан эхлэлийн тайланг хүлээлгэн өгсөн.
- 2.2 Зөвлөх багийн гишүүдийн ажлын удирдамжийн дагуу 2-р үе шатны ажлын хүрээнд гол оролцогч талуудтай уулзаж, шаардлагатай мэдээлэл, тоо баримт, зуух солих хөтөлбөрийн баримт бичгүүдтэй танилцаж, ус халаах жижиг зуухтай холбогдох стандартууд, туршилтын протоколуудыг харьцуулан судалж шинжлэн стандарт боловсруулах дэс дарааллыг тогтоосон.
- 2.3 Холбогдох талууд, судлаач эрдэмтэдийн төлөөллийг оролцуулан судалгааны үр дүн, стандартын төслийн хэлэлцүүлгийг хийж, гарсан саналуудыг стандартын төсөлд тусган гол оролцогч талууд болон холбогдох яам, мэргэжлийн байгууллагууд, үйлдвэрлэгчдэд илгээн тэдний албан ёсны санал, шүүмж, зөвлөмжүүдийг авч MNS 5041: 2016 “20 кВт хүртэл чадалтай ус халаах жижиг зуух. Техникийн ерөнхий шаардлага, турших арга ба яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын эцсийн хувилбарыг боловсруулан СХЗГ-ын эрчим хүчний ба Байгаль орчны стандартчилалын техникийн хорооны болон СХЗГ-ын үндэсний зөвлөлөөр оруулахаар илгээсэн.
- 2.4 СХЗГ-ын эрчим хүчний ба Байгаль орчны техникийн хорооны нарийн бичгийн дарга нар болон зарим гишүүд MNS 5041: 2016 “20 кВт хүртэл чадалтай ус халаах жижиг зуух. Техникийн ерөнхий шаардлага, турших арга ба яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын хувилбарыг MNS 5457 : 2005 “Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын (CO, SO₂, NO_x, үнс) зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.” стандарттай нэгтгэн өөрчилж стандартчилалын техникийн хорооны хурлаар оруулах санал өгсөн.

III. Төслийн явцын тайлан 2-оос хойших зөвлөхийн үйл ажиллагаа

- 3.1 СХЗГ-ын эрчим хүчний ба Байгаль орчны техникийн хороодын саналыг үндэслэн MNS 5041: 2016 “20 кВт хүртэл чадалтай ус халаах жижиг зуух. Техникийн ерөнхий шаардлага, турших арга ба яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын хувилбар болон MNS 5457 : 2005 “Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын (CO, SO₂, NO_x, үнс) зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.” стандартуудыг нэгтгэх судалгааг хийж зуухны чадлын ангилалд харгалзуулан заалтуудыг тодорхойлон стандартчилалын техникийн хороодын хурлаар оруулах эцсийн хувилбарыг бэлтгэсэн.
- 3.2 MNS 5041: 2016 “20 кВт хүртэл чадалтай ус халаах жижиг зуух. Техникийн ерөнхий шаардлага, турших арга ба яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын эцсийн хувилбарын төслийг 2016

- оны 11-р сарын 18 –ны өдөр СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх үед гишүүдийн саналаар ус халаах зуухнуудын стандарттай нэгтгэсэн стандартын нэрийг MNS 5043: 2016 “4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” гэж өөрчлөн СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн батлуулахаар дэмжсэн.
- 3.3 СХЗГ-ын эрчим хүчний техникийн хорооны хурлаас гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийн дагуу стандартын нэрийг MNS 5043: 2016 “4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” гэж өөрчилж, хэл найруулгын талаар зарим засвар хийгээд эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны нарийн бичгийн даргатай хамтран стандартын албан ёсны хэлбэрт оруулан СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх төслийг бэлэн болгосон.
- 3.4 СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж дэмжсэн MNS 5043: 2016 “4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” стандартын эцсийн хувилбарын төслийг 2016 оны 11-р сарын 24–ны өдөр СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцээд батласан.
- 3.5 MNS 5043: 2016 “4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг хянан англи хэл дээр орчуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- 3.6 СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэж батласан MNS 5043: 2016 “4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг монгол, англи хэл дээр бичиж хавсаргав.
- 3.7 СХЗГ-ын эрчим хүчний стандартчилалын техникийн хорооны хурлын тэмдэглэл, СХЗГ-ын үндэсний зөвлөлийн хурлын тогтоолыг хавсаргав.

Хавсралт 1

MNS 5043 : 2016

Агуулга

| | | |
|----------|---|----|
| Өмнөх үг | | |
| 1 | Хамрах хүрээ | 3 |
| 2 | Норматив ишлэл | 3 |
| 3 | Нэр, томъёо тодорхойлолт | 4 |
| 4 | Зуухны төрөл, техникийн үндсэн үзүүлэлт | 8 |
| 5 | Техникийн ерөнхий шаардлага | 10 |
| 6 | Байгаль орчны шаардлага буюу гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ | 14 |
| 7 | Аюулгүй ажиллагааны шаардлага | 15 |
| 8 | Иж бүрдэл | 16 |
| 9 | Шалгах, хүлээн авах | 17 |
| 10 | Туршилтын арга | 18 |
| 11 | Хаяглах, савлах, тээвэрлэх, хадгалах | 21 |
| 12 | Ашиглалтын холбогдох заалтууд | 22 |
| 13 | Үйлдвэрлэгчийн баталгаажуулалт | 22 |
| 14 | А Хавсралт. Стандартад хэрэглэсэн үзүүлэлтүүдийн тэмдэглэгээ, хэмжих нэгж | 23 |
| 15 | Б Хавсралт. Туршилтын үр дүнг боловсруулах тооцооны аргачлал | 24 |
| 16 | Ном зүй | 27 |

Өмнөх үг

Стандартчилал, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) Олон Улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь тухайн салбарын улсын стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороогоор хэлэлцэж 75-аас доошгүй хувийн саналаар зөвшилцсөн стандартын төслийг Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөл (СХҮЗ)-ийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Улаанбаатар Цэвэр Агаар Төсөл, Төслийг удирдах нэгжийн “Гэрийн зуухны одоо мөрдөгдөж байгаа стандартыг бүрэн шаталттай сайжруулсан зуухны бодит үзүүлэлттэй ойртуулан шинэчлэн сайжруулах зөвлөх үйлчилгээ” төслийн хүрээнд зөвлөх баг боловсруулав.

Энэ стандартыг Эрчим хүчний техникийн хороо ба Байгаль орчны техникийн хороогоор хэлэлцэн зөвшилцөж, Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн тогтоолоор баталсан болно.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ (Төсөл)

Ангилалтын код 27.060

| | |
|---|--|
| 4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага | MNS 5043:2016 |
| Hot-water boilers with heating capacity to 4,2 MW. General technical requirements. | MNS 5041:2001, MNS 5043:2001 ба MNS 5457 : 2005- ын оронд |

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2016 оны 11- р сарын 24-ний 50 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2017 оны 4 сарын 1- нээс эхлэн хүчинтэй.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн норматив шаардлагуудыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандартаар 0,7 МПа хүртэл даралттай усыг 115 °С-ын температур хүртэл халаах 4,2 МВт хүртэл чадалтай зуух (цаашид: зуух гэнэ)-ыг үйлдвэрлэх импортлоход хамаарна. Энэхүү стандартаар ус халаах зуухны тэмдэглэгээ, техникийн үзүүлэлт, техникийн ерөнхий шаардлага, шалгах, турших, хүлээн авах болон туршилтын арга, гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооно.

Нүүрс, хий ба шингэн түлшнээс гадна модны үртэс, холтос зэрэг шатамхай материалаар ажиллах зууханд энэхүү стандартыг баримтлана.

Энэхүү стандарт нь нүүрс, хий болон шингэнээр ажиллах 4,2 МВт-аас дээш чадалтай ус халаах зуух ба дулааны цахилгаан станцын зууханд үл хамаарна.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэсэн. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

2.1 MNS 1-1: 2006 Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг:

Техникийн ажлын журам.

2.2 MNS 1-2: 2006 Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг:

Стандартын бүтэц ба боловсруулах.

2.3 ISO/IEC Удирдамж 1-р хэсэг. 2016. Техникийн ажлын журам.

2.4 ISO/IEC Удирдамж 2-р хэсэг. 2016. Стандартын бүтэц ба боловсруулах.

2.5 www.estandard.mn сайт. Стандартыг хэрхэн бичих вэ? зөвлөмж

2.6 MNS4585:2016 Агаарын орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага

2.7 MNS 5568:2005, Шингэн түлшээр ажилладаг ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага.

2.8 BS EN 13240:2001, Хатуу түлшээр ажилладаг гэрийн зуух. Техникийн ерөнхий шаардлага ба шалгах арга.

2.9 ГОСТ 20548-87. 100 кВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага.

2.10 ГОСТ 30735-2001. 0,1- ээс 4,0 МВт чадалтай халаалтын зуухнууд. Техникийн ерөнхий шаардлага.

2.11 Стандарт PN EN 303-5:2012 300 кВт хүртэл чадалтай хатуу түлшээр ажиллах гар ба автомат ажиллагаатай зуух. АҮК ба бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

2.12 ГОСТ Р 50831: 1995 Зуухны төхөөрөмжийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулах бодисын гаралтын норм

2.13 GB 13271: 2001 Халаалтын зуухны түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулах бодисын гаралтын зөвшөөрөгдөх хэмжээ

2.14 GB 5468:1991 Зуухны утаан дахь тоосыг хэмжих арга.

3. Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1.

агаар өгөлтийг хянах

Шаталтыг тэтгэхэд шаардлагатай агаарын хэмжээг хянаж тохируулах автомат удирдлагын төхөөрөмж;

3.2

анхдагч агаар

Ул ширэмний доороос түлшний давхаргад өгч байгаа галыг тэтгэх агаар;

3.3

ашигт үйлийн коэффициент

Түлшийг шатаахад ялгарсан дулааны хэдэн хувийг ашигтай зарцуулж байгааг илэрхийлэх үзүүлэлт;

3.4

бага чадлын дулааны үүсгүүр

Нүүрс, шингэн түлш болон хийгээр ажиллах 4,2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух бүхий халаалтын зуухны газар.

3.6

бодит түлш

Зууханд түлж байгаа төрөл бүрийн түлш

3.7

бохирдуулах бодисын гаралтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Бага чадлын дулааны үүсгүүрийн зуухнаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын хэмжээний дээд хязгаар буюу агаар мандлыг бохирдуулах эх үүсвэр бүрээс хаягдах хорт бодисын дээд хэмжээ

ТАЙЛБАР: Энэ нь г/с, эсвэл т/жил-ээр илэрхийлэгдэх бөгөөд бусад эх үүсвэрийн хаягдалтай нэгдэж, тархасны дараа хүний амьсгалын түвшний агаар дахь агууламж нь хорт бодисын зөвшөөрөгдөх агууламжаас ихгүй байна.

3.8

бохирдуулах бодисын массын агууламж

Нэг шоо метр утаанд агуулагдаж байгаа бохирдуулах бодисын массын хэмжээ, мг/м³-ээр илэрхийлнэ.

3.9**бохирдуулах бодисын эзлэхүүний агууламж**

Нэг шоо метр утаанд агуулагдаж байгаа бохирдуулах бодисын эзлэхүүн, $1\text{ см}^3/\text{м}^3 = 1\text{ ppm}$ -ээр илэрхийлнэ.

ТАЙЛБАР: 1 ppm – хийн эзлэхүүний сая хуваасны нэг хэсэг, 10^{-6}

3.10**галын хотол**

Түлшний шаталтын процесс дотор нь явагддаг, зуухны зориулалт болон тухайн түлшний шинж чанарт тохируулан зохион бүтээсэн тоноглол

3.11**буцлах давхаргатай галын хотол**

Агаарын өгсөх урсгалаар үлээгдэн эрчимтэй хөдөлгөөнд орсон жижиг ширхэгт материалын давхарга дотор түлш шатаах технологи бүхий галын хотол

3.12**гар ажиллагаатай галын хотол**

Түлш өгөх, ул ширэм дээрх түлшний шатаж байгаа давхаргыг шилгээх, шаарга, үнс гаргах ажиллагааг бүгдийг гараар гүйцэтгэнэ.

3.13**дулааны бүтээмж**

Зуухны нэгж хугацаанд түгээсэн дулааны хэмжээ

3.14**дулааны нэрлэсэн хүчин чадал**

Үйлдвэрлэгчээс тогтоосон болон техникийн нөхцлийг хангасан түлшийг зууханд шатааж балансын туршилтаар лабораторийн нөхцөлд тодорхойлсон ус халаахад зарцуулсан дулааны хэмжээ;

3.15**дулаан түгээлт**

Нэгж хугацаанд усаар түгээсэн дулааны дундаж тоо хэмжээ;

3.16**дулаан түгээх усны зарцуулалтын хяналт**

Зууханд орох, гарах усны температур өгөгдсөн утганд байхад эргэлтийн усны зарцуулалтыг хэмжиж хянах зориулалттай хэмжүүр;

3.17**жишмэл түлш**

29.3 МДж/кг буюу 7000 ккал/кг дулаан гаргах чадвар буюу илчлэгтэй түлш.

ТАЙЛБАР: Байгаль дээрх бүх төрлийн түлшний илчлэг буюу дулаан гаргах чадвар өөр өөр байдаг тул тэдгээрийг хооронд нь жишиж харьцуулахын тулд нэг утганд шилжүүлэх шаардлагын үүднээс олон улсын хэмжээнд хэрэглэх болсон ойлголт юм. Бодит түлшийг дараах байдлаар жишмэл түлшинд шилжүүлнэ.

$$V_{\text{ж.т}} = V_{\text{хк}} = V_{\text{х}}(Q_{\text{г}}^{\text{г}}/7000) = V_{\text{х}}(Q_{\text{г}}^{\text{г}}/29.3) \quad (1)$$

Энд V , $Q_{\text{г}}^{\text{г}}$ - бодит түлшний дулаан гаргах доод чадвар буюу илчлэг.

3.18 илүүдэл агаарын коэффициент, α

Нэгж хэмжээний түлшний шаталтанд зарцуулсан агаарын бодит хэмжээг онолын хувьд шаардлагатай агаарын хэмжээнд харьцуулсан утга.

ТАЙЛБАР: Зуух тус бүрийн хийц, түлшний шаталтын нөхцлөөс хамаарч харилцан адилгүй өөр өөр байна.

3.19

механикжсан галын хотол

Түлш өгөх, ул ширэм дээрх түлшний шатаж байгаа давхаргыг шилгээх, шаарга, үнс гаргах ажиллагаа бүгд механикжсан байна.

3.20

нүүрстөрөгчийн дутуу ислийн ялгарал

Зуухны яндангаар утаанд агуулагдаж гарах нүүрстөрөгчийн дутуу ислийн (CO) хэмжээ.

3.21

нэг кг түлшний шаталтаас үүсэх бохирдуулах бодисын хэмжээ

Нэг кг бодит буюу жишмэл түлшний шаталтаас үүссэн утаан дахь агаар бохирдуулах бодисуудын хэмжээг мг/кг.т буюу мг/кг.ж.т нэгжээр илэрхийлнэ.

3.22

температурын мэдрэгч

Тасалгааны агаарын температураас хамааруулан галыг тэтгэгч агаарын зарцуулалтыг их, бага болгон автоматаар тохируулах хэрэгслийн мэдрэмтгий хэсэг;

3.23

тоосонцорын ялгарал

Зуухны яндангаар утаанд агуулагдаж гарах тоосонцорын хэмжээ;

3.24

түлшний ам

Зөвхөн түлш өгөх зориулалтаар ашиглагддаг нээх, хаах боломжтой нугас, түгжээ бүхий ам;

3.25

түлшний бункер

Үндсэн төхөөрөмжтэйгээ нэг цогц болон угсрагдсан, галын хотлыг түлшээр тэжээх үүрэгтэй түлш хадгалах сав;

3.26

түлшний илчлэг (дулаан гаргах доод чадвар),

Нэг кг түлшийг бүрэн шатаахад ялгарах нийт дулаанаас түүний чийглэгийг болон устөрөгчийн шаталтаас үүсэх усны уурыг ууршуулах дулааны хэмжээг хассаныг түүний илчлэг буюу дулаан гаргах доод чадвар гэнэ.

ТАЙЛБАР: Түлшний төрөл, агуулгаас хамааран шаталтаас ялгарах дулааны хэмжээ харилцан адилгүй байна.

3.27

түлшний үнслэг

Хатуу түлшний бүрэн шаталтын дараа үлдсэн усанд үл уусах бодис;

3.28

ул ширэм

Түлшний үелсэн шаталт явуулах, шаталтанд шаардлагатай агаар нэвтрүүлэх, үнс буулгах зориулалтын нүхтэй галын хотлын доор байрлуулсан түлшний шаталтын дулааны хүчдэлийг тэсвэрлэх чадвартай ширмэн сараалж;

3.29**ул ширэмний хавирга**

Суурин болон салдаг байдлаар цутгагдсан ул ширэмний сараалж болж байгаа хавирга;

3.30**ус халаах жижиг зуух**

Төрөл бүрийн түлшээр ажилладаг галын хотол, түүнд тохирсон халаах гадаргуу бүхий 20 кВт хүртэл чадалтай дулааны эх үүсгүүр;

3.31**ус халаах зуухны утааны зам (хийн хөндий)**

Халаах гадаргуугаар бүхэлдээ болон хэсэгчлэн тоноглогдсон, галын хотлоос яндан хүртэлх утаа дайран өнгөрөх хэсэг;

3.32**усны эргэлтийн систем**

Усан халаалтын зуух, хэрэгцээний халуун ус хангамж болон халаах хэрэгсэл тэдгээрт хамаарах шугам хоолойг дүүргэж тасралтгүй эргэлтэд байгаа усыг агуулж буй нийт систем;

3.33**утааны температур**

Гэрийн тооноор яндан гарах цэгт хэмжсэн утааны температур;

3.34**утааны хий**

Шаталтын процессийн бүтээгдэхүүн болон зуухнаас гарч байгаа хэд хэдэн төрлийн хийнээс бүрдэх хийн төлөвт бодис;

3.35**утааны хийн тойруу шугам**

Яндан руу шууд холбогдсон утааны хийн үндсэн шугам хэвийн бус байх тохиолдолд ашиглах, ердийн үед хаалттай байх бэлтгэл хоолой;

ТАЙЛБАР: Тойруу шугам нь утааны хийтэй тээвэрлэгдэж яваа усны уур яндан дотор хувирсан ус болохоос урдчилан сэргийлж, түргэн хугацаанд урдчилан халаах зориулалтаар ашиглагдаж болно.

3.36**утааны хийн массын зарцуулат**

Зуухнаас нэгж хугацаанд гарч байгаа утааны хийн массын хэмжээ;

3.37**утааны хийн хаалт**

Утааны хийн зарцуулалтыг өөрчлөх механизм;

3.38**үнсний сав**

Үнсний тосгуурын гадна гэр буюу зориулалтын хийц загвартай, хааж нээж болох амтай хэсэг;

3.39**үнсний тосгуур**

Ул ширэмнээс унасан үнсийг хуримтлуулах зориулалттай, үнсний савнаас сугалж авах боломжтой тусгай хэв маяг бүхий шургуулга хэлбэрийн сав;

3.40**үнс зайлуулах**

Ул ширмэн дээрх түлшний үеийн доод хэсгийг цэвэрлэх ба шаталтын бүтээгдэхүүн үнсийг цуглуулах сав руу гаргах үйл явц;

3.41**үнсийг зайлуулах механизм**

Шатаж байгаа түлшний давхаргын ёроолын хэсгээс үнсний үлдэгдлийг зайлуулах зориулалттай төхөөрөмж;

ТАЙЛБАР: Үнс зайлуулах механизм нь зарим тоноглолд ул ширмийг хөдөлгөөнд оруулах, хөмрөх зориулалтаар хэрэглэгдэнэ.

3.42**хагас механикжсан галын хотол**

Түлш өгөх, ул ширэм дээрх түлшний шатаж байгаа давхаргыг шилгээх, шаарга, үнс гаргах 3 үйлдлийн аль 1 нь буюу 2 нь механикжсан байна.

3.43**халаах гадаргуу**

Түлшний шаталтаас ялгарах дулааныг усанд дамжуулах гадаргуу

3.44**хэвийн нөхцөл**

Зуухны утааны даралт 101325 Па, температур 273 К байх нөхцөл

3.45**яндангийн таталтын тохируулга**

Ул ширэмний доороос өгөх агаарын зарцуулалтыг тохируулснаар яндангийн таталтыг хянах боломжийг бүрдүүлж байгаа хаалт буюу сойлтуур;

3.46**яндангийн таталт**

Үндсэн төхөөрөмж дотор гал асаж байгаа геометр тэнхлэг дээр сонгосон тодорхой цэгийн статик даралт, яндан дээр хэмжилт хийж байгаа цэг дэх статик даралтын зөрүү;

4. Зуухны төрөл, техникийн үзүүлэлт

4.1 Зуухыг олон түлшний ба тусгай түлшний гэж ангилна. Зуухны зарим эд ангид зохих өөрчлөлт оруулан хатуу (нэг буюу хэд хэдэн төрлийн), шингэн буюу хийн түлшээр ажиллах зуухыг олон түлшний зуух гэнэ. Түлш шатаах аргыг өөрчлөхгүйгээр нэг буюу хэд хэдэн төрлийн түлшээр ажиллах зуухыг тусгай түлшний зуух гэдэг.

Түлшний төрлөөр:

- а. Хатуу (мод, модный хаягдал, нүүрс, шахмал түлш) түлшний
- б. Хийн (нүүрсний хий, шингэрүүлсэн хий гэх мэт) түлшний
- с. Шингэн (дизель түлш) түлшний


4.2 Тэмдэглэгээ

4.2.1. Зуухны галын хотол ба түлшний төрлийг заахдаа дараах тэмдэглэгээг хэрэглэнэ.

Үүнд:

А– автомат шатаагуур; М– механикжсан ба хагас механикжсан галын хотол;
Ч - чулуун нүүрс; Х– хүрэн нүүрс; М- мазут; А– антрацит; Д_б– бага даралтанд шатаах хий; Шт – тунгалаг шингэн түлш; УЗ– уурын зуух; УХЗ – ус халаах зуух.

Ус халаах зуухны маркийн тэмдэглэгээ



ЖИШЭЭ: Зуухны төрөл, чадлын үзүүлэлтийг:

- Хүрэн нүүрс түлдэг, гар ба механикжсан ажиллагаатай галын хотол бүхий 1,0 МВт чадалтай ус халаах зуух: $УХЗ - 1,0 X MNS \dots\dots\dots$;
 $УХЗм - 1,0 X MNS \dots\dots\dots$;
- Хүрэн нүүрс түлдэг, буцлах давхарга бүхий галын хотолтой 1,0 МВт чадалтай ус халаах зуух: $УХЗбд - 1,0 X MNS \dots\dots\dots$;
- Бага даралттай шатах хий түлдэг, хий-шингэний автомат шатаагуур бүхий 1,25 МВт чадалтай ус халаах зуух: $УХЗа - 1,25Дб/ MNS \dots\dots\dots$ гэж тус тус

ТЭМДЭГЛЭНЭ.

ТАЙЛБАР: Техникийн бичиг баримт дээр зуухны тэмдэглэгээ, чадлыг энэ стандартын дагуу тэмдэглэсний дараа зуух үйлдвэрлэгч байгууллагын тусгайлан өгсөн нэрийг хаалтанд харуулж болно.

Хүрэн нүүрс түлдэг гар ажиллагаатай галын хотолтой 0,8 МВт (0,7 Гкал/ц) чадалтай ДТХ – 0,7 ус халаах зуух: $УХЗ - 0.8 X (ДТХ - 0,7) MNS \dots\dots$

4.3 Зуухны жин, нэрлэсэн чадал, усны ажлын даралтын хэмжээг тухайн зуух тус бүрийн техникийн нөхцөлд заана. Зуухны төрөл болон техникийн үзүүлэлтийг 1-р хүснэгтэнд үзүүлэв. Зуух бүрийн АҮК хүснэгтэнд заасан утгаас багагүй байна.

1-р хүснэгт. Зуухны нэрлэсэн чадлын ангилал ба АҮК

| Зуухны төрөл | Түлшний төрөл | Дулаан үйлдвэрлэх чадал*, МВт (хэлбэлзэл 7 %) | Ашигт үйлийн коэффициентийн доод утга, % |
|---|--|---|--|
| Гар ажиллагаатай галын хотолтой | Чулуун нүүрс | 0,005; 0,010; 0,012 5; 0,016; 0,020; 0,025; 0,0315; 0,040; 0,050; 0,063; 0,080. | 75 |
| | Хүрэн нүүрс | 0,005; 0,010; 0,012 5; 0,016; 0,020; 0,025; 0,0315; 0,040; 0,050; 0,063; 0,080 | 70 |
| Гар ажиллагаатай болон механикжсан, хагас механикжсан галын хотолтой | Чулуун нүүрс | 0,10; 0,163; 0,233; 0,40; 0,6; 0,80; 1,0; 1,25; 1,4; 1,6; 2,0; 2,32; 2,8; 3,25; 4,2 | 78 80 |
| | Хүрэн нүүрс | 0,10; 0,163; 0,233; 0,40; 0,6; 0,80; 1,0; 1,25; 1,4; 1,6; 2,0; 2,32; 2,8; 3,25; 4,2 | 70 75 |
| Шингэн ба хийн түлшээр ажилладаг автомат ажиллагаа бүхий | шингэн түлш, байгалийн хий, нүүрсний хий, шингэрүүлсэн хий | 0,005, 0,010, 0,012 5, 0,016, 0,020, 0,025, 0,031 5, 0,040, 0,050, 0,063, 0,080 | 85 |
| | | 0,10; 0,163; 0,233; 0,40; 0,60; 0,80; 1,0 | 90 |
| | | 1,25; 1,4; 1,6; 2,0; 2,32; 2,8; 3,25; 4,2 | 91 |
| * Зуухны техникийн бичиг баримт дээр тэмдэглэгдсэн дулаан үйлдвэрлэх чадлын хэмжээ нь энэ заасан хязгаарт багтаж байх шаардлагатай. | | | |

4.4 Зуухны нэрлэсэн чадал болон ашигт үйлийн коэффициент (АҮК) нь зөвхөн зураг төслөөр авсан түлшинд тооцогдоно. Хэрэв ангилсан нүүрсний оронд ангилж ялгаагүй нүүрс хэрэглэвэл зуухны нэрлэсэн чадал 85 % хүртэл буурна.

- 4.5** Гар ажиллагаатай зуухны нэрлэсэн чадал түлшний төрлөөс хамаарч дараах хэмжээнээс хэтрэхгүй байх шаардлагатай. Үүнд:
- a. Мод, модны төрлийн түлш, хүлэр түлэхэд – 0,3 МВт
 - b. Хүрэн нүүрс түлэхэд- 0,5 МВт
 - c. Чулуун нүүрс ба антрацит түлэхэд - 0,8 МВт
- 4.6** Олон төрлийн түлш түлдэг 80 кВт хүртэл чадалтай зуухны ажиллагааны нэг цикл үргэлжлэх хугацаа дор зааснаас багагүй байна. Үүнд:
- a. 17 % хүртэл дэгдэмхий бодис бүхий антрацит ба чулуун нүүрс түлдэг зууханд 8 цагаас
 - b. 47 % хүртэл дэгдэмхий бодистой бүхий чулуун ба хүрэн нүүрсийг түлдэг зууханд 6 цагаас
- 4.7** Тусгай түлш түлдэг түлшний 80 кВт хүртэл чадалтай зуухны ажиллагааны нэг цикл үргэлжлэх хугацаа дор зааснаас багагүй байна. Үүнд:
- a. 17 % хүртэл дэгдэмхий бодистой антрацит ба чулуун нүүрс түлдэг зууханд 12 цагаас
 - b. 47 % хүртэл дэгдэмхий бодистой чулуун ба хүрэн нүүрсийг түлдэг зууханд 8 цагаас
- 4.8** Ус халаах зуухыг уурын зуух болгон өөрчлөх буюу ус халаах зуухыг халуун усны технологийн хэрэглээний системд тогтмол ачаалалтайгаар ажиллуулах нөхцөлд уг зуухны нэрлэсэн чадлыг 85% хүртэл бууруулна.
- 4.9** Ердийн шаталттай зуух нэрлэсэн чадлаар ажиллах нөхцөлд яндангаар гарч байгаа утааны температур 160 °C –ээс их байж болохгүй.

5. Техникийн ерөнхий шаардлага

- 5.1** Зуух ба түүний эд ангиуд, сэлбэг хэсгүүдийг энэхүү стандартын шаардлагад нийцүүлэн зохих журмаар баталсан технологийн заавар, ажлын зургийн дагуу үйлдвэрлэнэ.
- 5.2** Зуух төхөөрөмжлөлтийг цаг уурын нөхцлийг харгалзсан 4.2 ангилалд нийцүүлэн стандартын дагуу гүйцэтгэнэ.
- 5.3** Зуухны халаах гадаргууг ширмээр буюу ширэм, гангийн аль алиныг нь оролцуулж бэлтгэж болно.
- 5.4** Саарал ширмэн цугтамалд MNS 0766-77 стандартад заасан техникийн шаардлагыг мөрдөнө. Зуухны матмал болон хэвлэмэл эд ангиуд, бүрээс, ам нь гадна талдаа ан цав, ханзралт, элдэв арзгар, үзүүртэй зүйлгүй байх шаардлагатай.
- 5.5** Ширмэн зуухны нягтруулгын шаардлагыг техникийн нөхцлөөр тогтооно.
- 5.6** Зуухны ширмэн эдлэл MNS BS EN 13240:2011 стандартын 4.2.2.2-д заасан шаардлагуудыг хангасан байна.
- 5.7** Нээлхийн тагийг нээхэд хялбар, бүх халаах гадаргууг зориулалтын хэрэгсэлүүдийг ашиглан утааны хийн талаас шалгаж цэвэрлэхэд дөхөмтөй байна.
- 5.8** Хажуу тийшээ нээгдэх ам нь 100 градусаас багагүй өнцгөөр онгойдог байх шаардлагатай.
- 5.9** Ус халаах жижиг зуух буюу 20 кВт чадалтай зуухны галын хотлын дээрх тогоо суух амсрын таг нь нягт нийлж байх ба уг таг нь өөрөө аяндаа онгойх боломжгүй (түгжээтэй) байна.
- 5.10** Ган болон ширмэн зуухны хэсгүүд, холбоос хоолойнууд ажлын даралтыг тэсвэрлэхүйц бөх бат, бин битүү нягтрал сайтай, гаралтдаа хамгаалах хавхлага (клапан), манометртэй байна.
- 5.11** Ус халаах зуухны түлш шатаах тавцан буюу ул нь ширмэн цугтамал сараалж буюу усан хөргөлттэй хоолой байж болно.

- 5.12** Механик ажиллагаатай галын хотол, автомат шатаагууртай зуух нь аюулгүй ажиллагааны автомат төхөөрөмж, зуухны ажиллагааны технологийн үзүүлэлтийг удирдах, хянах, дохио өгөх багаж хэрэгслээр тоноглогдсон байна.
- 5.13** Зуухны хийц бүтээц нь галын хотолд засвар үйлчилгээ хийх, халаах гадаргуугийн гадна талыг цэвэрлэх, хянах-хэмжих багаж хэрэгслийн заалтыг харах, багажуудад тохируулга, зүгшрүүлэлт боломжийг бүрдүүлсэн байна.
- 5.14** Зуухны чадлын тохируулах дээд ба доод хязгаар (тухайн зуухны техникийн нөхцөлд өөрөөр заагаагүй бол) 17 % хүртэл дэгдэмхий бодис агуулсан нүүрс түлэхэд 35 %-110 %, өөр төрлийн хатуу түлш хэрэглэхэд 50 %-110 % тус тус байна. Хийн болон шингэн түлшээр ажилладаг зуух хүчин чадлаа автоматаар тохируулдаг байх хэрэгтэй. Механик ажиллагаатай галын хотол, шингэн ба хийн түлшний шатаагуурууд нь зуухны ачаалал нэрлэсэн чадлынхаа 36-110 %-ийн хязгаарт ажиллах чадвартай байна.
- 5.15** Түлшний шаталтанд шаардлагатай анхдагч ба хоёрдогч агаарын хэмжээг өөрчлөн тохируулах (боломжтой) энгийн хэрэгсэлтэй байна.
- 5.16** Ажлын биеийн даралтанд байнга ажилладаг эд ангийн статик бөх батын (илүүдэл даралтын хамгийн их утгад харьцуулсан) нөөц ширэмд 4, ганд 2 дахин их байна.
- 5.17** Ус халаах зуух нэрлэсэн чадлаараа ажиллаж байх нөхцөлд, ус дамжуулах хоолойн гадаргуугийн температур нь усны буцлах температураас 25 °C-аас илүү температуртай байж болохгүй. Зуух нэрлэсэн чадлаар ажиллаж байхад халаах гадаргуугийн температурын хамгийн их утга 250 °C-аас хэтрэх ёсгүй. Хавирган хэлбэртэй халаах гадаргуугийн оройн хэсэг ба түүнтэй шүргэлцэж буй хоолойн температурын ялгаа 70 °C-аас илүү байж болохгүй.
- 5.18** Зуухны ашиглалтын нийт хугацаа 10 жилээс доошгүй байна.
- 5.19** Секцүүдийг багцалж (пакетууд) татаж холбоход хэрэглэдэг болон даралтанд ажилладаг ширмэн эд ангиудыг (үүнд холбогч ниппель хамаарахгүй) СЧ 15-аас доошгүй маркийн саарал ширмээр хийнэ.
- 5.20** Холбогч ниппель (хоолой)-ийг стандартын дагуу “феррит ангилалтын” давтамл ширмээр бэлтгэдэг. Ниппелийг мөн СТ 3_{пс}, СТ 3_{сп}, СТ 2_{пс}, СТ 2_{сп} маркийн гангаар бэлтгэнэ.
- 5.21** Цутгамал эд ангийн масс, хэв хэмжээ ба механик боловсруулалтын үеийн тавилын зөрөө нь нарийвчлалын хувьд хийц бүтээцийн бичиг баримтад заасан шаардлагатай тохирч байх шаардлагатай.
- 5.22** Ган хийцийн зуухны халаах гадаргууг хийхэд эгшин зуурын эсэргүүцэл нь 520 Н/мм²- аас ихгүй, харьцангуй суналт 20 %-иас багагүй нүүрстөрөгчжүүлсэн, 600 Н/мм²- аас ихгүй, харьцангуй суналт 20 %-иас багагүй ферлтийн ангилалын, галд тэсвэртэй ба 800 Н/мм²- аас ихгүй, харьцангуй суналт 35 %-иас багагүй байх аустинитын ангилалын ган хэрэглэхийг зөвшөөрнө.
- 5.23** Зуухны ган угсармал хийц, хэсэг нь ан цав, цууралтгүй, сэтэрхийгүй, ирмэггүй байна.
- 5.24** Зуухны эд ангийн бөх батад нөлөөлөхгүй гэм согогийг засаж, сайжруулах ажил хийхийг зөвшөөрнө. Харин галын хотлын дотор цацрагийн нөлөөнд байдаг зуухны секцийн хоолойнуудад засаж сайжруулах ажил хийхийг зөвшөөрөхгүй.
- 5.25** Гагнууран холболтын оёос холбогдох стандартын шаардлага хангасан байна.

5.26 Зуухны даралтанд ажиллах эд ангиудын ханын зузаан 2-р хүснэгтэнд зааснаас багагүй байна.

2-р хүснэгт. Зуухны эд ангиудын ханын зузаан

| № | Материал | Цацрагаар дулаан хүлээн авах халаах гадаргуу (хоолойноос бусад), конвекцийн халаах гадаргуугийн хавтгай хана | Халахгүй хана (хоолойноос бусад), конвекцийн халаах гадаргуу | Хоолой |
|---|---|--|--|--------|
| 1 | Нүүрстөрөгчжүүлсэн ган ба хөнгөн цагааны хайлшин цувимал | 5 | 4 | 2,9 |
| | Зэвэрдэггүй ган ба зэсийн хайлшан цувимал | 3 | 2 | 1 |
| 2 | Саарал ширмэн ба хөнгөн цагааны хайлшин цутгамал Давтмал ширмэн ба зэсийн хайлшан цутгамал | 5 4,5 | | |

5.27 Тулгаж холбосон хавирган хэлбэртэй секцийн хавтгай чанарын зөвшөөрөгдөх хэмжээ стандартад заасан нарийвчлалын зэрэгтэй тохирч байх ёстой. Зэрэгцэн байрласан секцүүд хавирган хавтангийн хоорондын зай нь нягтруулга хийхээс өмнө 1мм-ээс илүүгүй байна.

ТАЙЛБАР: Зуух үйлдвэрлэх технологийн дагуу зэрэгцэн нийлж байгаа хэсгүүдийн хоорондын зайн нягтралыг угсралтын явцад гүйцэтгэж, нягтруулалтын өмнө хэмжих боломжгүй тохиолдолд секц хоорондын зайн нягтын чанарын шаардлагыг тухайн зуухны техникийн нөхцөлд зааж өгнө.

5.28 Ус халаах зуухны (хийц загвар нь) хоолойн системийн ба усан цамцны бүх хэсэгт ус тасралтгүй эргэх нөхцлийг хангахын зэрэгцээ халаах гадаргуугийн хамгийн дээд цэгт агаар гаргах, доод цэгт ус юүлэх хаалтууд угсарсан байна. Агаар гаргах хоолойн диаметр 15 мм-ээс, юүлэх хоолойнх 20 мм –ээс багагүй байна.

5.29 Ниппель холбоосын нягтруулалт ажлын зурагт заасан хүлцэлийн дагуу шахагдсан байх ёстой. Тэдгээрт төмрийн будаг хэрэглэхийг зөвшөөрнө.

5.29 Зуухны галын хотлын төхөөрөмжийн (гарнитурын) хөдөлгөөнтэй эд ангиуд нь аажим хөдөлдөг байна. Галын хотлын ам зуухны гадна талд нягт сууж өгсөн байх ба ам нь хаалттай үед 2 мм-ээс илүүгүй зай завсартай байх ёстой.

5.31 Эд ангийн хөндлөн (метрийн) эрэг болон түүний хүлцэлийн хэмжээг стандартад заасан нарийвчлалын ангилалаар бэлтгэх бөгөөд хоолойны цилиндр эрээсийг В ангилалаар нарийвчлан бэлтгэнэ.

5.32 Зуухны даралтад ажилладаг эд ангиуд ба угсрагдсан хэсгүүд нь усан шахалтаар дараах даралтыг даах ёстой. Үүнд:

- Зуухны ширмэн секц, эд ангиуд (нипелээс бусад) $(4x_{pa}+0.2)$ МПа-аас (p_a -ажлын даралт) багагүй даралтанд 3 минутаас доошгүй хугацаанд;
- Ус халаах зуухны гагнасан багцууд ба эд ангиуд $2x_{pa}$ МПа –аас багагүй даралтанд 5 минут;

5.33 20 кВт хүртэл чадалтай зуухыг халаалтын системтэй холбох богино хоолойн диаметр 40 мм, харин 20 кВт-аас дээш чадалтай зуухных 50 мм-ээс дээш байна. Зуухнаас ус гарах богино хоолойн залгагдах хэсэг тус бүр цилиндр эрээсүүдтэй байх ёстой. Харин зуухыг сүлжээнд холбох 80 мм ба түүнээс дээш диаметртай хоолойд эрээсэн бус фланцен холболт ашиглахыг зөвшөөрнө.

5.34 Утаа сорогчгүй буюу ердийн таталттай зуухны нэрлэсэн чадлын үеийн сүүлийн хэсгийн сийрэгжилт дараах утгуудаас ихгүй байна.

3-р хүснэгт. Ердийн таталттай зуухны сүүлийн хэсгийн сийрэгжилт

| | | | | | | | | |
|--------------------------------|-------------|-----------|-------|-------|-----|-----|-----|---------|
| Зуухны нэрлэсэн чадал, МВт | 0,02 хүртэл | 0,025-0,1 | 0,163 | 0,233 | 0,4 | 0,6 | 0,8 | 1,0-4,2 |
| Сүүлийн хэсгийн сийрэгжилт, Па | 25 | 40 | 52 | 58 | 64 | 72 | 76 | 80 |

5.35 Утаа сорогчтой зуухны нэрлэсэн чадлын үеийн аэродинамикийн эсэргүүцэл дараах утгуудаас ихгүй байна

4-р хүснэгт. Утаа сорогчтой зуухны аэродинамикийн эсэргүүцэл

| | | | | | | | | | | | | | | | |
|-------------------------------|-----|-------|-------|-----|-----|-----|-----|------|-----|-----|-----|------|-----|------|-------|
| Зуухны нэрлэсэн чадал, МВт | 0,1 | 0,163 | 0,233 | 0,4 | 0,6 | 0,8 | 1,0 | 1,25 | 1,4 | 1,6 | 2,0 | 2,32 | 2,8 | 3,25 | 4,2 |
| Аэродинамикийн эсэргүүцэл, Па | 75 | 200 | 300 | 450 | 560 | 640 | 700 | 750 | 775 | 800 | 850 | 880 | 920 | 950 | 1 000 |

5.36 Өрлөг, дулаалга, гадна гадаргуугийн температур

5.36.1 Өргөн хэрэглээний зориулалтаар борлуулах 80 кВт хүртэл чадалтай зуухны будгийн төрөл, дулаан тэсвэрлэх чанарыг тусгайлан заасны дагуу сонгох бөгөөд будгийн төрөл нь 5-р хүснэгтэд заасан ангилалаар шийдвэрлэгдэнэ. Харин өргөн хэрэглээний биш захиалгаар үйлдвэрлэж байгаа зуухны будгийн төрөл, чанарыг үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн хоорондын зөвшилцлийн үндсэн дээр тогтооно.

5-р хүснэгт. зуухны будгийн төрөл, ангилал

| Зуухны гадна талын будагдах гадаргуу | Будгийн ангилал | Ашиглалтын нөхцлийг онцгой орчноор тогтооно |
|--------------------------------------|-----------------|---|
| Гадна бүрхээс | IV | - |
| Галын хотлын ам | VII | 120 °C |
| Бусад гадаргуу | VII | 80 °C |

5.36.2 Бүх зуухны өрлөг, дулаалгыг ашиглалтын хэвийн нөхцөлд хортой бодис ялгаруулахгүй, ашиглалтын хугацаанд нөлөөлөхөөргүй галд тэсвэртэй буюу шатахгүй материалаар хийнэ.

5.36.3 Зуухны ам, ажиглах ба цэвэрлэгээний зориулалтын нээлхийнүүдийн таг болон бусад дулаалгагүй хэсгүүдийн гадна гадаргуугийн температур орчны агаарын температураас 100 °C-ээс ихгүй байна.

5.36.480 кВт хүртэл чадалтай зуухны гадна гадаргуугийн температур дараах хэмжээнээс их байж болохгүй. Үүнд:

- a. Хажуу хана ба зуухны дээд тал 50 °C
- b. Нүүрний ба арын хана 80 °C
- c. Галын хотлын ам 120 °C
- d. Галын хотлын амны бариул 45 °C
- e. Мөн зуухны доод шалны температур 70 °C -аас илүүгүй байна.

5.36.5 Зуухны амны бариул, хөшүүрэг болон гараар үйлчлэхэд зориулсан хэсгүүдийн температур орчны агаарын температураас дараах хэмжээнээс ихгүй байна. Үүнд:

- a. Металл ба түүнтэй төстэй материал – 35 °C;
- b. Шаазан ба түүнтэй төстэй материал – 45 °C;
- c. Хуванцар ба түүнтэй төстэй материал – 60 °C.

- 5.36.6** Зуухны нэрлэсэн чадлын ба усны дундаж температур $80\text{ }^{\circ}\text{C}$ байх үед өрлөг дулаалгын гадна гадаргуугийн температур тасалгааны агаарын температураас $30\text{ }^{\circ}\text{C}$ -ээс ихгүй байна.
- 5.37** Ашиглалтын үед зуухны дулааны чадал үйлдвэрлэгчийн заасан хязгаарт буюу зайцад байх шаардлагатай.
- ТАЙЛБАР: Зуухны АҮК ба агаар бохирдуулах бодисуудын ялгаруулалт энэхүү стандартын шаардлагыг хангахаар тогтвортой ажиллах чадлын зайцыг хэлнэ.
- 5.38** Халаалтын зуухны яндангийн өндөр түүний орчинд 200 м -ээс дотогш зайд байрлаж байгаа барилга байгууламжаас 3 м -ээс дээш байна.
- 5.39** Яндангийн гарах огтолын диаметр нь түүнээс гарах утааны хурд тухайн орчны салхины дундаж хурднаас 2 дахин их байх нөхцлийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

6. Байгаль орчны шаардлага буюу гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

- 6.1** Зуухнаас гарах утааны найрлага дахь нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын дан ба давхар исэл (NO_x), хүхрийн давхар исэл (SO_2), тоосонцорын агууламжийг тэдгээрийн хэвийн ажиллагааны үед зориулалтын баталгаажуулсан багаж, хэрэгслээр хэмжиж тодорхойлно.
- 6.2** Энэхүү стандартыг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хойш шинээр үйлдвэрлэж, суурилуулах, өргөтгөх, өөрчлөх зуух тус бүрээс гарах утааны сувагт болон бүх зуухны утааны ерөнхий сувагт буюу янданд утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын хэмжээг тодорхойлох зориулалтын хэмжих багаж, хэрэгслийн анхдагчийг байрлуулах боломж бүхий тагтай нүх гаргасан байх шаардлагатай.
- 6.3** Зуухнаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын хэмжээг дараах тохиолдолд баталгаажуулсан хэмжүүрээр хэмжиж шалгана. Үүнд:
- Шинээр ашиглалтанд оруулсны дараа;
 - Шинэчлэл, өөрчлөлт буюу засвар хийсний дараа;
 - 2 жил тутамд тогтмол 1 удаа;
 - Эрх бүхий байгууллага, хүмүүс экологийн хяналт шалгалт хийх үед;
 - Эзэмшигч буюу хэрэглэгчид хүсэлт тавьсан тохиолдолд.
- 6.4** Хэмжилт хийхийн өмнө зуухыг галлан хэвийн ажиллагаанд оруулсан байх бөгөөд бодит чадал нь нэрлэсэн чадлын 70% - иас доошгүй байх үед хэмжиж, үр дүнг 2 -р хавсралтанд заасан аргачлалын дагуу хэвийн нөхцөл буюу агаарын даралт 101325 Па (760 мм.мү.б), температур 273 К ($0\text{ }^{\circ}\text{C}$), илүүдэл агаарын коэффициент 1.9 -тэй тэнцүү ($\alpha=1.9$ буюу $\text{O}_2=10\%$) байх нөхцөлд шилжүүлэн тооцож энэ стандартын 6 -р хүснэгт дэх зөвшөөрөгдөх утгуудтай харьцуулан хянана.
- 6.5** Гарах утааны хий дэх бохирдуулах бодисуудын агууламжийг туршилтаар тодорхойлон зуух бүрийн ашиглалтын зааварт оруулсан байх ёстой.
- 6.6** Тухайн хэмжүүрийн заалтын нэгжээс хамааран утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын агууламжийг “ppm” буюу мг/м^3 - ээр тодорхойлж болно.
- 6.7** Зуухнаас гарах утааны найрлага дахь нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын дан ба давхар исэл (NO_x), хүхрийн давхар исэл (SO_2), тоосонцорын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 6 -р хүснэгтэнд заасан хязгаарт байна.

6-р хүснэгт. Бохирдуулах бодисуудын зөвшөөрөндөх дээд хэмжээ

| д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Зуухны хүчин чадал (Q), МВт | | | |
|-----|----------|-------------|-----------------------------|-----|-----------------------|-----------------------|
| | | | 0.08 МВт хүртэл | | $0.1 \leq Q \leq 0.8$ | $1.0 \leq Q \leq 4.2$ |
| | | | Түлшний төрөл | | | |
| | | | Шингэн | Хий | Хатуу | |

| | | | | | | | |
|---|--|--------------------|------|------|--------|-------|-------|
| 1 | Нийт тоосонцор буюу TSP | мг/нм ³ | - | - | 225 | 600 | 400 |
| | | мг/МДж* | - | - | 120 | 320 | 215 |
| | | мг/кг.ж.т | - | - | 2840 | 9400 | 6150 |
| 2 | Нарийн ширхэглэгт тоосонцор- PM2.5 | мг/нм ³ | - | - | 170 | 400 | 300 |
| | | мг/МДж* | - | - | 90 | 215 | 160 |
| | | мг/кг.ж.т | - | - | 1970 | 6270 | 4615 |
| 3 | Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | мг/нм ³ | 115 | 120 | 9700 | 5000 | 4000 |
| | | мг/МДж* | 35 | 35 | 6800 | 2870 | 2130 |
| | | мг/кг.ж.т | 1025 | 1060 | 140000 | 78000 | 62400 |
| 4 | Хүхрийн давхар исэл (SO ₂) болон хүхэрт нэгдэл | мг/нм ³ | - | - | 1000 | 800 | 600 |
| | | мг/МДж* | - | - | 540 | 400 | 300 |
| | | мг/кг.ж.т | - | - | 11880 | 12000 | 900 |
| 5 | Азотын исэл (NO _x) | мг/нм ³ | 230 | 240 | 500 | 450 | 400 |
| | | мг/МДж* | 70 | 75 | 300 | 230 | 200 |
| | | мг/кг.ж.т | 2050 | 2110 | 6800 | 6750 | 6000 |

Тайлбар: *-хэрэглэгчид түгээх 1 МДж дулаан

7. Аюулгүй ажиллагааны шаардлага

- 7.1** Үйлдвэрлэгч зуухыг итгэмжлэгдсэн лаборатори буюу эрх бүхий мэргэжлийн байгууллагаар туршуулан дүгнэлт гаргуулж, Мэргэжлийн хяналтын газар, Гамшиг судлалын лабораторийн дүгнэлт зэргийг үндэслэн Монгол улсын тохирлын гэрчилгээ авч баталгаажуулсан байх бөгөөд худалдаалж буй зуухнуудад аюулгүй ажиллагааны ба ашиглалтын зааврыг дагалдуулан хэрэглэгчдэд хүлээлгэн өгсөн байх ёстой.
- 7.2** Шатдаг хийгээр ажилладаг зуухны хийц, бүтээц, угсралт, ашиглалт нь Дэд бүтцийн сайдын баталсан “Хийн аж ахуйн аюулгүйн ажиллагааны дүрэм”-ийн шаардлагад нийцсэн байна.
- 7.3** 100 кВт хүртэл чадалтай зуухыг ашиглахдаа “Орон сууц, зочид буудал, нийтийн байр, албан байгууллагын барилга, хувийн грашийн галын аюулгүй байдлын үлгэрчилсэн дүрэм”- ийг мөрдлөг болгоно.
- 7.4** Зуух болон тогооны нийт хэсгийн доод цэгээс ус, хурдасыг зайлуулах боломж бүхий үлээлгийн хоолойтой байна.
- 7.5** Ус халаах зуухны дээд талын гурвалсан хоолой буюу гарах шугам дээр (ус явах чиглэлээр) ерөнхий хаалтны өмнө талд манометр, усны температур заах багаж ба зуухыг усаар дүүргэх үед агаар зайлуулах зориулалттай жижиг хаалт бүхий хоолой тавигдсан байх шаардлагатай.
- 7.6** Ус халаах зуухны ус орох, гарах хоолойнууд дээр зуухыг дулаан хангамжийн системээс бүрэн таслах зориулттай ерөнхий хаалт тавигдах ёстой. Гарах хоолой дээрх ерөнхий хаалт нь 50 мм- ээс доошгүй диаметр бүхий тойруу шугамтай байна.
- 7.7** Ажлын байранд оршдог хөдлөх механизм бүрт гадна талаар нь хашлага хамгаалалт байх шаардлагатай.
- 7.8** 100 кВт хүртэл чадалтай зуухны утааны яндангийн сойлтуур чөлөөтэй хөдөлж, хаах хэсэг нь нийт огтлолын 75 %-аас ихгүй буюу бүрэн таглахааргүй байвал зохино.
- 7.9** Зуухны иж бүрдэлд орсон үлээх, сорох механизм нь зохих стандартын шаардлагыг хангасан байвал зохино.
- 7.10** Зууханд шатаагуурын ажиллагааг хянах зорилгоор түүнд таглаа бүхий үзлэгийн цонх гаргаж өгнө.
- 7.11** Хий ба шингэн түлшээр ажилладаг зуух нь тэсрэлтийн хавхлагаар тоноглогдсон байх бөгөөд нэг хавхлагийн талбай нь 0,05 м²-аас багагүй байна. Галын хотлын ба утааны сувгийн 1м³ эзлэхүүн бүрт хавхлагын 0,05 м²-аас багагүй талбай оногдохоор тооцож зууханд байвал зохих хавхлагын тоог тодорхойлно. Тэсрэлтийн хавхлаг ба

бусад хамгаалах хэрэгслийн байршил нь "Хийн аж ахуйн аюулгүй дүрэм"- д нийцэж байх ёстой.

- 7.12** Мазутаар ажилладаг зуухны түлшний хоолой дээр шатаагуурын өмнө талд мазутын температурыг хэмжих хэрэгслэл байрлуулна.
- 7.13** Шингэн ба хийн түлшээр ажилладаг зуухны аюулаас хамгаалах автомат төхөөрөмж нь цахилгаан тасрах буюу шатаагуурын гал унтраах (тэдгээр нь ажиллаж байх үед тасалдах учиргүй) нөхцөлд галын хотлын түлш өгөлтийг шууд зогсоодог байх шаардлагатай. Түүнчлэн технологийн дараах үзүүлэлтийн аль нэг нь зөвшөөрөх хязгаарын утганд хүрсэн тохиолдолд дээрх автомат төхөөрөмж ажиллаж, түлш өгөлтийг шууд зогсооно. Үүнд:
- a. шатаагуурын өмнөх хийн даралт;
 - b. галын хотол дахь сийрэгжилт (зуухны соролт тогтвортой баригдах нөхцөлд);
 - c. зуухны гарах усны температур, даралт;
 - d. үлээх салхилууртай зуухны шатаагуурын өмнө талын агаарын даралт тус тус хамаарна.
- 7.14** Механикжсан ажиллагаатай галын хотол бүхий зуухны аюулаас хамгаалах автомат төхөөрөмж цахилгаан тасрах нөхцөлд буюу доорх техникийн үзүүлэлтийн аль нэг нь үл зөвшөөрөх хязгаарын утганд хүрсэн тохиолдолд галын хотлын түлш өгөлт болон салхилуурыг шууд зогсооно. Үүнд:
- a. галын хотлын сийрэгжилт
 - b. ул ширэмний доороос үлээх агаарын даралт;
 - c. галын хотлын сийрэгжилт;
 - d. зуухнаас гарч байгаа усны температур, даралт.
- 7.15.** Зуух ажиллаж байхад хяналтын цэгүүд дээрх шуугианы түвшин 85 дБ-аас хэтрэхгүй байх ёстой.

8. Иж бүрдэл

- 8.1** Зуухны иж бүрдэлд дараах зүйлүүд орно. Үүнд:
- a. Хаалт, тохируулагч арматур, галын хотлын гарнитур, хянан хэмжих хэрэгсэлүүд;
 - b. Сэлбэг хэрэгслийн жагсаалтанд тусгагдсан багаж хэрэгсэл, туслах тоноглол;
 - c. Механик ажиллагаатай галын хотол буюу шатаагуур, зуухны автомат төхөөрөмж;
 - d. Тухайн зуухны техникийн нөхцөлд тусгагдсан түлш өгөх, үнс шаарга зайлуулах, агаар үлээх, утаа сорох тоноглол;
 - e. Гадна бүрээс;
 - f. Хатуу ба шингэн түлшээр ажиллах зуухны халаах гадаргууг хаг, хурдаснаас цэвэрлэх хэрэгсэл.
- 8.2** Зуух болон түүний иж бүрдэлд багтдаг тоноглолуудад (галын хотол, шатаагуур, автомат төхөөргүүд, хянах болон хэмжих хэрэгсэл, үлээх, сорох төхөөрөмж) ашиглалтын бичиг баримтыг хавсаргасан байна. Үүнд:
- a. техникийн паспорт;
 - b. техникийн тодорхойлолт;
 - c. дулааны, аэродинамик, гидравлик ба бөх батын тооцоо;
 - d. угсралтын ба ашиглалтын заавар.

Ашиглалтын эдгээр бичиг баримтуудыг нэг хавтсанд нэгтгэн нэг баримт бичиг болгосон байж болно.

8.3 Ашиглалтын эдгээр бичиг баримтуудад зуухны зураг, техникийн үзүүлэлтүүд, угсралт, ашиглалтын зааврыг оруулсан байх ёстой.

8.3.1 Зуухны техникийн үзүүлэлтүүдэд дараах үзүүлэлтүүдийг оруулна. Үүнд:

- a. түлшний төрөл;
- b. бүх төрлийн түлш түлэх үеийн нэрлэсэн чадал (дулааны чадлын хязгаар буюу зайц) ;
- c. нэрлэсэн ба доод чадлын үеийн гарах утааны температур;
- d. илүүдэл агаарын коэффициент;
- e. галын хотлын сийрэгжилт;
- f. аэродинамикийн эсэргүүцэл;
- g. зууханд орох гарах усны температурын зөрүү 10 °C- ээс...25 °C байх үеийн гидравлик эсэргүүцэл;
- h. АҮК;
- i. агаар бохирдуулах бодисуудын агууламж (CO, NO_x, SO₂, дэгдэмхий үнс буюу тоосонцор гэх мэт);
- j. усны дээд даралт;
- k. усны дээд температур;
- l. температурын тохируулгын зайц;
- m. зууханд орох усны доод температур;
- n. усны эзлэхүүн;
- o. галын хотлын хэмжээ;
- p. ашиглалтын хугацаа гэх мэт.

8.3.2 Угсралтын зааварт зуухыг халаалтын системд холбох схем болон дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- a. зуухны хийц;
- b. зуухны суурь, өрлөг, дулаалгын онцлог;
- c. усан шахалтын (гидравлик туршилт) үр дүн;
- d. хийн хөндийн халаах гадаргуугийн хэмжээ;
- e. зуухны барилгад тавигдах шаардлага;
- f. аюулгүй ажиллагааны норм, дүрэм.

8.3.3 Ашиглалтын зааварт дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- a. зуухыг галлах, явуулах, зогсоох, аваарын нөхцөлд дулааны чадлыг өөрчлөх үйл ажиллагаа;
- c. зуухны халаах гадаргуугийн дотор ба гадна бохирдлоос цэвэрлэх арга,
- d. түлшийг зөв сонгох, бэлтгэх, үүсэх бохирдуулах бодисуудыг бууруулах арга зам;
- e. ажиллагсадад зориулсан зөвлөмж.

9. Шалгах, хүлээн авах

9.1 Зуух энэхүү стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд үйлдвэрлэгч байгууллага нь хүлээн авах шалгалт хийж, тодорхой хугацаанд туршилт, сорилт хийж гүйцэтгэнэ.

- 9.2** Эд анги болон угсармал хийц, нэгж нь энэ стандартын 5.4-5.10, 5.23, 5.24, 5.29, 5.32, 5.38-д заасан шаардлагыг хангаж буй эсэхэд нэг бүрчлэн хүлээн авах шалгалтыг хийнэ.
- 9.3** Хүлээн авах шалгалтыг түүвэрчлэн хийх нөхцөлд ээлжинд үйлдвэрлэсэн зуухны 5 %-д энэ стандартын 5.1, 5.5, 5.30, 5.31-д заасан шаардлага, секцийн 2% ба бэлэн угсарсан зуух, хавтангийн 10 %-д энэ стандартын 5.28-д заасан шаардлага мөрдөгдсөн эсэхийг шалгана.
- 9.4** Тодорхой хугацаанд хийх туршилт, сорилтыг дараах байдлаар гүйцэтгэнэ.
- даралтанд ажилладаг 5-аас доошгүй тооны секц (гагнаж угсарсан нэгж)-ийн статик нягтралыг (5.16) жилд нэг удаа шалгах;
 - шингэн ба хийн түлшээр ажилладаг болон механикжсан галын хотолтой зуухны автомат төхөөрөмж (7.13, 7.14)-ийг 3 жилд нэгээс доошгүй удаа сонгож авсан нэг иж бүрдэл дээр шалгах;
 - тогтоосон аргачлалын дагуу гаргасан статистик өгөгдлийн үндсэн дээр зуухны найдвартай ажиллагааны үзүүлэлт (5.19)-ийг 3 жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулж байх;
 - Ус халаах жижиг зуух нь 4.3, 4.6, 4.7, 5.14, 7.3- д заасан шаардлага хангаж буйд 3 жилд нэгээс доошгүй удаа ээлжит туршилт хийж шалгах бөгөөд уг туршилтанд хүлээн авалтын шалгалтад орсон зуухнуудаас зөвхөн нэгийг хамруулна.
 - Цутгамал эд ангиудын хэмжээ болон массыг 3 сард нэг удаа шалгах. Үүнд массыг 3-аас доошгүй эд ангид, хэмжээг 2-оос доошгүй эд анги дээр тус тус шалгавал зохино.

ТАЙЛБАР: Энэхүү стандартын 4.3, 4.7, 5.2, 5.13, 5.17, 5.31, 5.34, 5.35, 7.15-д заасан шаардлагуудыг зуух хүлээн авах туршилтын үед шалгана.

9.5 Шалгах арга

- 9.5.1** Хэмжилтийн зохих нарийвчлал бүхий түгээмэл (универсал) болон тусгай зориулалтын хэмжих багажуудаар эд анги, угсармал нэгжийн хэмжээг (5.1, 5.21, 5.24, 5.27) шалгана.
- 9.5.2** Зуухны гадна хэлбэр, угсралтын бүрэн зөв байдал болон иж бүрдэлтийг (5.1, 5.29, 8.1, 8.2) зураг төслийн бичиг баримттай тулган үзэж шалгана.
- 9.5.3** 5.32 дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан эсэхийг зохих журмын дагуу батлагдсан загвар бүтээцтэй харьцуулж шалгана.
- 9.5.4** Угсрагсан зуухны зай завсарыг (5.27, 5.30) 0.1 мм-ээс илүүгүй хэмжээсийн алдаа бүхий тэмтрүүл (шүп)-ийн тусламжтайгаар шалгана.
- 9.5.5** Тулгаж холбосон хавирган хэлбэртэй багцуудын гадаргуугийн тэгш байдлын хүлцэлийн хэмжээг (5.27)-д хянах хавтан дээр тавьж (хэмжлийн алдаа 0.1мм-ээс хэтрэхгүй) шалгана.

10 Туршилтын арга


10.1 Бат бөх ба нягтын туршилт

10.1.1 Бат бөх ба нягтралыг 9.2 дугаар зүйлийн дагуу шалгана.

10.1.2 Хийн болон агаарын даралтан дор ажилладаг эд анги, угсармал нэгжүүдэд 8-р хүснэгтэнд заасны дагуу нягтын туршилт хийнэ.

8-р хүснэгт. Нягтын туршилт хийх даралт, хугацаа

| Хий болон агаарын илүүдэл даралт, кПа | Туршилтын илүүдэл даралт, кПа | Туршилт үргэлжлэх хугацаа, мин | Туршилт хийж байх үед даралт буурах зөвшөөрөгдөх хэмжээ, кПа |
|---------------------------------------|-------------------------------|--------------------------------|--|
| 5 кПа хүртэл (5 кПа орно.) | 5 | 5 | 0,2 |
| 5 кПа-аас дээш | 100 | 60 | 1,5 |



1-р зураг. Зуухны нягтралыг шалгах туршилт хийх схем. 1. Утаа гарах хэсэг; 2. зуух; 3. Зуухны ам; 4, 6, 7. Тохируулах хаалт; 5. зарцуулалтын хэмжүүр; 8. үлээх салхилуур.

10.1.3 Үлээх салхилуурыг ажиллуулан галын хотолд зуухны аэродинамикийн нэрлэсэн эсэргүүцлээс 20 % илүү даралт үүсгэн тогтмол барина. Туршилтын үед хэмжсэн агаарын зарцуулалтын бодит утгыг хэвийн нөхцөлд ($p=101\ 325$ Па, $t=273$ К) дараах томъёогоор шилжүүлнэ.

$$V_x = (B + p) \frac{0.359 \cdot V}{t + 273} \quad (1)$$

Энд: В- атмосферийн даралт, мм.му.б;

p- зарцуулалтын хэмжүүрийн өмнөх агаарын даралт, мм.му.б;

t- зарцуулалтын хэмжүүрийн өмнөх агаарын температур;

V- зарцуулалтын хэмжилтийн утга, м³/ц.

